



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 01 сарын 28 өдөр

Дугаар А/73

Ховд

Хөрөнгө оруулалтын эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2-ын "а", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.2, 46.3, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн наймдугаар хуралдааны 8/04 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 8 дугаар тогтоолын 2, 3 дугаар хавсралтын 2019 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталж, худалдан авах ажиллагаа зохион байгуулах эрхийг Дөргөн сумын Засаг дарга / О.Заяа/-д шилжүүлсүгэй.
2. Эрх шилжсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний зураг төсөв, ажлын даалгавар, техникийн тодорхойлолтыг үндэслэлтэй боловсруулж 2 дугаар сарын 20-ны дотор Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсээр хянуулан баталгаажуулсны үндсэн дээр, худалдан авах ажиллагааг 3 дугаар сарын 25-ны дотор холбогдох хууль, журмын дагуу ил тод, нээлттэй, шуурхай зохион байгуулж, гүйцэтгэгчийг шалгаруулан гэрээ байгуулж, ашиглалтанд хүлээн авах зэрэг хэрэгжилтийг хангах арга хэмжээ авч, үр дүнг 8 дугаар сарын 20-ны дотор тайлагнахыг сумын Засаг дарга /О.Заяа/-д даалгасугай.
3. Эрх шилжүүлж буй хөрөнгө оруулалтын захиалагчийн хяналтыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга /С.Гантөмөр/ Нийгмийн бодлогын хэлтсийн дарга /Д.Даваадорж/ нарт хариуцуулсугай.

4. Худалдан авах ажиллагааны хэрэгжилтэнд хяналт тавьж, өмч бүртгэлд тусгахыг Орон нутгийн өмчийн газрын дарга /Ш.Нохойжав/, холбогдох бичиг баримтын бүрдлийг хянаж санхүүжүүлж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга /С.Гантөмөр/, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/ нарт үүрэг болгосугай.

5. Энэхүү захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д даалгасугай.


ЗАСАГ ДАРГА



Б. ДҮГЭРЖАВ



Аймгийн Засаг даргын 2019 оны
01 дүгээр сарын 28-ны өдрийн А/73 дугаар
захирамжийн хавсралт



ЭРХ ШИЛЖҮҮЛСЭН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Төрөл	Эхлэх	Дуусах	Төсөвт өртөг	Санхүүжих дүн /сая төгрөг/
1	Цэцэрлэгийн гадна талбайн тохижилт /Дөргөн сум/ ОНХС-4,5-с	Шинэ	2019	2019	35.0	35.0
2	ЕБС-ийн техник тоног төхөөрөмж авах /Дөргөн сум/ ОНХО-2,5-с	Шинэ	2019	2019	10.0	10.0
3	Бярвааз засварлах /Дөргөн сум/ ОНХО-3,2-с	Шинэ	2019	2019	15.0	15.0
4	Ус, хогны машины засвар /Дөргөн сум/ ОНХО-3,7-с	Шинэ	2019	2019	10.0	10.0
Дүн					70.0	70.0

-oOo-